

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014.09.23

Дугаар А/245

Улаанбаатар хот

“Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл” батлах тухай

Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.18–д тусгасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл”-ийг нэгдүгээр хавсралт, нэр томъёоны тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын дарга /онцгой байдлын хурандаа Б.Мандахгэрэл/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Санхүү, ар талын газрын дарга /онцгой байдлын хурандаа М.Энх-Амар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА

Т.ДУЛАМДОРЖ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2014 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн
А/245 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

**“ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОНЦГОЙ БАЙДЛЫН
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ”**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт (1990-2015), Мянганы хөгжлийн зорилтууд (2005-2015), Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021), “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр (2011), Шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2012-2016), Олон улсын “Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц” Тунхаглал, түүний үйл ажиллагааны хөтөлбөр (2000-2015)-ийн хүрээнд хүүхэд хамгааллын асуудалтай уялдуулан Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага нь 18 хүртэлх насны хүүхдийг гамшиг, осол, тэдгээрийн аюулд өртөх хамгийн эмзэг нийгмийн бүлэг хэмээн үзэж тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалагдах эрхийг хангахад хариуцлага хүлээнэ.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, түүний албан хаагч нь ажил, үүргээ гүйцэтгэхдээ хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалтай холбоотой үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хүүхдийн эрхэм дээд, язгуур эрх ашгийг хамгаалах, хүүхдэд аюулгүй орчинг бүрдүүлэх үүрэгтээ хариуцлагатай хандана.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүүхэд бүрийг гэр бүлдээ тайван амьдрах, боловсролын болон нийгмийн бусад хүрээнд аюулгүй орчинд байх үндсэн нөхцлийг бүрдүүлж, тэднийг анхааран халамжлах, хамгаалах үүрэгтээ ухамсартай хандана.

2. ЗОРИЛГО

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэлийн зорилго нь гамшгаас хамгаалах бодлого, стратеги, үйл ажиллагааныхаа хүрээнд хүүхэд бүрийг хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөгөөс хамгаалахад тодорхой хувь нэмэр оруулж, энэ талаар бүх талуудтай хамтран ажиллах хэм хэмжээг зохицуулахад оршино.

3. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү чиглэл нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын анги, байгууллага, тэдгээрийн албан хаагч, гэрээт болон гамшгаас хамгаалах сайн дурынхан, хамтран ажиллагч төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, бусад иргэдэд хамаарна.

4. ҮНДСЭН ЗАРЧИМ

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын талаар дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

- 4.1. Хүүхдийн эрхэм дээд, язгуур эрх ашгийг хамгаалах;
- 4.2. Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;
- 4.3. Хүүхэд хамгааллын түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 4.4. Хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, үр дүнд чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;

5. БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

5.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах;

5.2. Хүүхдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан гамшгийн бэлэн байдлыг хангах, сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

5.3. Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих;

5.4. Гамшгийн үед хүүхдийг хамгаалах чадавхийг сайжруулах;

5.5. Хүүхдийн эрхэм дээд, язгуур эрхийг хамгаалахад мэдрэмжтэй, хариуцлагатай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

6. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

6.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын хүүхэд хамгааллын талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах чиглэлийн хүрээнд:

6.1.1. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх үндэсний болон Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;

6.1.2. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;

6.1.3. Гамшгаас хамгаалах чиглэлээр гарч байгаа бодлогын болон эрх зүйн баримт бичигт хүүхэд хамгааллын асуудлыг тусгах;

6.1.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагчдад хүүхэд хамгааллын талаар ойлголт өгөх сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

6.2. Хүүхдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан гамшгийн бэлэн байдлыг хангах, сургалт, сурталчилгааг зохион байгуулах чиглэлийн хүрээнд:

6.2.1. Хүүхдийг гамшгаас хамгаалах талаар өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судлан тодорхойлж, гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараах хүүхэд хамгааллын асуудлыг боловсронгуй болгох;

6.2.2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах талаарх ерөнхий агуулгыг тусгах;

6.2.3. Хүүхдийн насны онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн бэлэн байдлыг хангах тусгай хөтөлбөрийг боловсруулах;

6.2.4. Аймаг, нийслэлийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсронгуй болгох, үйл ажиллагааг сайжруулах;

6.2.5. Хүүхдэд учирч болзошгүй аюул, осол, гамшгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах арга замыг төлөвлөж, хэрэгжүүлэх;

6.2.6. Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэл, мөлжлөгт оруулж болзошгүй аливаа эрсдэлийг илрүүлэх, хяналт тавих, сөрөг нөлөөг багасгахад анхаарч ажиллах;

6.3. Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих чиглэлийн хүрээнд:

6.3.1. Хүүхдийн оролцооны стандартын зарчмыг баримталж, гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог хангах, хүүхдэд ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах;

6.3.2. Хүүхдийн амралт, чөлөөт цаг, хүмүүжил, төлөвшлийг дэмжсэн гамшгаас хамгаалах уралдаан, тэмцээн, аяныг зохион байгуулах;

6.3.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, дадлагад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх;

6.3.4. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 330 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулдаг “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургалт”-д хүүхдийн оролцоог хангах;

6.3.5. Ерөнхий боловсролын сургуулиудад “Өсвөрийн аврагч” клубыг байгуулж ажиллуулах, удирдлага, чиглэлээр хангах, клубын ажиллах журам боловсруулах;

6.3.6. “Өсвөрийн аврагч” тэмцээнийг бүс, аймаг, нийслэлийн хэмжээнд жил бүр зохион байгуулах;

6.3.7. Хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг, гамшиг, осол, аюулд өртсөн хүүхдийн талаар хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсаар мэдээлэх, онцгой байдал, цагдаа, яаралтай түргэн тусламж зэрэг чухал шаардлагатай утасны дугаарыг хүүхдүүдэд таниулах;

6.4. Гамшгийн үед хүүхдийг хамгаалах чадавхийг сайжруулах чиглэлийн хүрээнд:

6.4.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, улсын алба, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын асуудлыг тусгах;

6.4.2. Гамшгийн үед аврах, нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үед хүүхдийг нэн тэргүүнд анхаарах асуудлыг төлөвлөх зэрэг хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тэргүүн ээлжинд тавьж ажиллах;

6.4.3. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлаар онол, практикийн ном, сурах бичиг, гарын авлага, арга зүйг боловсруулж, хэвлэн түгээх;

6.4.4. Сургууль, цэцэрлэг болон бусад хүүхдийн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хүүхдийн оролцоотой боловсруулах, тэдэнд таниулах;

6.4.5. Гамшигт өртсөн хүүхдийн сэтгэл зүйн судалгаа хийх, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;

6.5. Хүүхдийн эрхэм дээд, язгуур эрхийг хамгаалах мэдрэмжтэй, хариуцлагатай гамшгаас хамгаалах түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлийн хүрээнд:

6.5.1. Хүүхэд хамгааллын талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил, сайн дурын байгууллага, иргэдийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

6.5.2. Хүүхэд хамгааллын талаарх төрийн ажил, үйлчилгээг иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэхийг дэмжих;

6.5.3. Хүүхэд болон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг салбар, байгууллага, ажилтнуудад гамшгаас хамгаалах мэдлэг эзэмшүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах сургалт явуулах;

6.5.4. Хүүхэд хамгааллын асуудлаар хамтрагч, түншлэгч нартай гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын талаар хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах;

6.5.5. Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын талаар төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

6.5.6. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын асуудлаар судалгаа, шинжилгээ явуулах, онол практик, эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулахыг дэмжиж, хамтран ажиллах;

7. САНХҮҮЖИЛТ

7.1. Хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ: Үүнд:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

7.1.2. Орон нутгийн хөгжлийн сан;

7.1.3. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төслийн хөрөнгө;

7.1.4. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандивын хөрөнгө;

7.1.5. Бусад эх үүсвэр;

8. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

8.1. Хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэлийг хэрэгжүүлэх нь Онцгой байдлын байгууллагын нийт албан хаагчийн үүрэг байна.

8.2. Хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэлийг жил бүр Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр томилсон ажлын хэсэг үнэлж дүгнэнэ.

8.3. Үндэсний болон олон улсын холбогдох хууль, эрх зүйн акт өөрчлөгдвөл тухайн үед нь энэхүү чиглэлд өөрчлөлт оруулах буюу шинэчлэн найруулж болно.

8.4. Хүүхэд хамгааллын талаар баримтлах чиглэл нь цаг үе, орчиндоо нийцсэн үр дүнтэй байна.

----- о О о -----

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2014 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн
А/245 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

“Хүүхэд “	18 нас хүртэлх хүнийг;
“Үе тэнгийнхний хүчирхийлэл”	Нэг хүүхэд нөгөө хүүхдээ бие махбодын эсвэл сэтгэл санааны дарамт хүчирхийлэлд оруулснаас бие махбод, сэтгэл санааг тавгүйтүүлэхийг;
“Хүүхдийн эсрэг хүчирхийлэл”	Дараах хэлбэрээр хүүхдийн бие махбод, сэтгэл санааны халдашгүй дархан байдлыг алдагдуулахыг; <ul style="list-style-type: none">• бие махбодийн хүчирхийлэл• бэлгийн хүчирхийлэл• сэтгэл санааны хүчирхийлэл• үл хайхрах• бүх хэлбэрийн мөлжлөг
“Сэтгэл санааны хүчирхийлэл”	Байнга голох, доромжлох, нэр төрийг нь гутаах, хүний эрхийг нь үгүйсгэх гэх мэтээр өөртөө итгэх итгэл, нийгмийн чадамжаа хүүхэд аажмаар гээхэд хүргэж байгаа бусдын сөрөг зан үйлийг;
“Бие махбодийн хүчирхийлэл”	Чимхэх, цохих, зодох, өшиглөх, хазах, түлэх, сэгсрэх гэх мэт ямар нэгэн байдлаар хүүхдийн бие махбодод байнга халдах, бие махбодийн гэмтэл учруулахыг;
“Үл хайхрах”	Хүүхдэд анхаарал тавихыг шууд, санаатайгаар орхигдуулж, тэдний наад захын хэрэгцээг хангах явцдаа алдаа гаргахыг;
“Бэлгийн хүчирхийлэл”	Хүүхдийг бэлгийн таашаал авахдаа ашиглах, эдийн засгийн ашиг олохоор биеийг нь үнэлүүлэхийг;
“Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл”	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаар нийгэмд тогтсон ойлголтын улмаас хүний хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэсэн хорт нөлөө бүхий аливаа үйл ажиллагааг;

**“Хүүхдийг садар
самуунд ашиглах”**

Бэлгийн амьдралыг ил тод харуулан дүрслэн бичсэн бичлэг, видео бичлэг, зураг бүтээхдээ хүүхдийг оролцуулахыг;

“Мөлжлөг”

Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, наймаалах, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг хонжоо олохыг;

“Уруу татах”

Хүүхдийг бэлгийн харилцаанд уруу татахын тулд хүүхэд болон түүний асран хамгаалагч нарын итгэлийг олохоор хийж буй үйлдлийг;

“Хүүхэд хамгаалал”

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг гарахаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэхэд чиглэсэн санаачлага, үйл ажиллагааг;

**“Хүүхдэд ээлтэй
байгууллага”**

Бие махбод, бэлгийн, сэтгэл санааны, сэтгэл зүйн хохирол, үл хайхрах байдлаас хүүхдийг хамгаалах үйл ажиллагааг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлсэн, дадал болгосон, дотоод журамдаа тусгасан, байгууллагын соёлд нэвт шингээсэн байгууллагыг;

“Хүүхэд хамгаалах бодлого”

Хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичгийг;

“Хүүхэдтэй тулж ажиллах”

Ажлын байрны тодорхойлолтын дагуу болон ажлын байрны орчинд хүүхэдтэй байнга холбоотой ажиллахыг;

**“Онцгой байдлын үе дэх
хүүхэд хамгаалал”**

Гамшиг, осол, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

“Гамшиг”

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг;

“Осол”

Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж, шугам сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдож

сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг;

“Аюулт үзэгдэл”

Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг;

”Онцгой байдал”

Гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүхийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг онцгой ажиллагаа явуулж байгаа нөхцлийг;

“Гамшгаас хамгаалах”

Гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх цогцолбор арга хэмжээг;

“Гамшгийн эрсдэл”

Гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохиролын магадлалыг;

“Урьдчилан сэргийлэх”

Гамшгийн аюул, болзошгүй хохирлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг.